

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ГАА-2022/09/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас: 99177546 Аудитор: С.Санчирмаа Утас:99282488	Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a> Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a> Цахим хаяг: <a href="mailto:Vujinkhandj@audit.gov.mn">Vujinkhandj@audit.gov.mn</a> Цахим хаяг: <a href="mailto:Sanchirmaas@audit.gov.mn">Sanchirmaas@audit.gov.mn</a>
---	---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	13
3.8 Аудитын гол асуудал .....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт .....	14
4.1 Залруулсан алдаа .....	14
4.2 Төлбөрийн акт .....	14
4.3 Албан шаардлага .....	15
4.4 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25 № 96

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ДЭЛГЭР  
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
О.БАЯНБАТ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлалгүйгээр тавилга бэлтгэсэн, цалингийн урьдчилгаа суутгаагүй, батлагдсан орон тооноос 1 орон тоо илүү ажиллуулсан, И баримтыг дутуу шивсэн, татварын тодорхойлолтоор зөрүү тооцоо татварын цахим системд бүртгэлтэй зэрэг 64.8 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1, 14.4 дэх заалт, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

07020136

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>118,061,880.05</b>	<b>119,423,187.05</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>35,367,686.20</b>	<b>35,151,093.20</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	383,508.20	383,508.20
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>34,984,178.00</b>	<b>34,767,585.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	380,000.00	380,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	34,604,178.00	34,387,585.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>82,694,193.85</b>	<b>84,272,093.85</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>7,784,193.85</b>	<b>9,362,093.85</b>
35410	Бичиг хэргийн материал	419,175.00	149,775.00
35420	Аж ахуйн материал	7,104,318.20	9,212,318.20
35440	Түлш, шатах тослох материал	260,700.65	0.65
35600	Мал амьтад	74,910,000.00	74,910,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>962,730,695.62</b>	<b>984,393,714.92</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>962,730,695.62</b>	<b>984,393,714.92</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>946,169,095.76</b>	<b>968,079,114.88</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	761,532,989.43	761,532,989.43
39202	Хуримтлагдсан элэгдэл	-110,963,357.72	-144,944,435.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	126,950,178.00	131,038,172.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-91,335,758.48	-94,749,857.49
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	358,423,411.00	354,616,649.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-243,989,683.23	-233,611,974.67
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	84,963,433.97	87,685,300.97
39208	Хуримтлагдсан элэгдэл	-60,189,912.16	-54,019,569.85
39214	Бусад үндсэн хөрөнгө	213,069,263.63	271,945,563.63
39215	Хуримтлагдсан элэгдэл	-95,520,702.68	-114,642,956.30
39217	Ном	3,229,234.00	3,229,234.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>16,561,599.86</b>	<b>16,314,600.04</b>
39301	Програм хангамж	1,740,000.00	1,740,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,491,000.14	-1,737,999.96
39303	Бусад биет бус хөрөнгө	16,312,600.00	16,312,600.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,080,792,575.67</b>	<b>1,103,816,901.97</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,080,792,575.67</b>	<b>1,103,816,901.97</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,080,792,575.67</b>	<b>1,103,816,901.97</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	626,748,340.32	626,748,340.32
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-75,361,057.52</b>	<b>-52,336,731.22</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-7,819,091.37	-76,590,650.52
51220	Тайлант үеийн үр дүн	-67,541,966.15	24,253,919.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	529,405,292.87	529,405,292.87
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,080,792,575.67</b>	<b>1,103,816,901.97</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>371,849,253.00</b>	<b>538,679,106.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>26,203,800.00</b>	<b>120,873,021.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>26,203,800.00</b>	<b>120,873,021.00</b>

<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>26,203,800.00</b>	<b>120,873,021.00</b>
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	26,203,800.00	120,873,021.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>345,645,453.00</b>	<b>417,806,085.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>22,961,453.00</b>	<b>60,445,085.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,961,453.00	60,445,085.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>322,684,000.00</b>	<b>357,361,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	322,684,000.00	357,361,000.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>439,391,219.15</b>	<b>514,342,686.70</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>439,391,219.15</b>	<b>514,342,686.70</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>430,368,113.86</b>	<b>482,804,916.71</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>219,905,898.73</b>	<b>217,387,720.43</b>
210101	Үндсэн цалин	136,522,117.36	163,364,522.03
210102	Нэмэгдэл	27,330,612.83	28,943,999.30
210104	Урамшуулал	35,181,465.07	0.00
210105	Гэрээт ажлын хөлс	20,871,703.47	25,079,199.10
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>28,216,389.73</b>	<b>27,569,536.58</b>
210201	Тэтгэврийн даатгал	26,414,348.66	19,726,437.94
210202	Тэтгэмжийн даатгал	394,135.77	1,960,799.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	402,108.63	1,568,599.50
210204	Ажилгүйдлийн даатгал	421,726.97	392,199.51
210205	Эрүүл мэндийн даатгал	584,069.70	3,921,499.80
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>18,159,480.88</b>	<b>25,712,137.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,930,105.88	1,972,419.00
210302	Түлш, халаалт	16,229,375.00	23,639,718.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	100,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>23,651,640.00</b>	<b>33,989,970.00</b>
210401	Бичиг хэрэг	2,361,800.00	2,628,250.00
210402	Тээвэр, шатахуун	18,617,810.00	25,380,340.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,215,830.00	1,430,680.00
210404	Ном, хэвлэл	200,000.00	50,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	596,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	756,200.00	3,904,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,292,000.00</b>	<b>2,624,250.00</b>
210502	Хоол, хүнс	392,000.00	430,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	900,000.00	2,194,250.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,375,000.00</b>	<b>7,489,170.00</b>
210604	Урсгал засвар	3,375,000.00	7,489,170.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,405,500.00</b>	<b>1,772,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,405,500.00	1,772,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>15,821,028.37</b>	<b>45,937,171.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,333,468.37	45,253,271.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	620,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	350,000.00	108,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	110,000.00	100,000.00

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	96,800.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	340,000.00
210807	Газрын төлбөр	90,760.00	135,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>118,541,176.15</b>	<b>120,322,961.70</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,200,000.00	14,202,760.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	245,000.00	330,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	108,096,176.15	105,790,201.70
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,023,105.29</b>	<b>31,537,769.99</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,833,000.00</b>	<b>2,099,604.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,833,000.00	2,099,604.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>7,190,105.29</b>	<b>29,438,165.99</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,739,120.66	14,246,351.99
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	450,984.63	15,191,814.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-67,541,966.15</b>	<b>24,336,419.30</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>82,500.00</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	82,500.00
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-67,541,966.15</b>	<b>24,253,919.30</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	626,748,340.32	529,405,292.87	-7,819,091.37	1,148,334,541.82
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	626,748,340.32	529,405,292.87	-7,819,091.37	1,148,334,541.82
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-67,541,966.15	-67,541,966.15
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	626,748,340.32	529,405,292.87	-75,361,057.52	1,080,792,575.67

<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>626,748,340.32</b>	<b>529,405,292.87</b>	<b>-75,361,057.52</b>	<b>1,080,792,575.67</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-1,229,593.00	-1,229,593.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>626,748,340.32</b>	<b>529,405,292.87</b>	<b>-76,590,650.52</b>	<b>1,079,562,982.67</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	24,253,919.30	24,253,919.30
<b>2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>626,748,340.32</b>	<b>529,405,292.87</b>	<b>-52,336,731.22</b>	<b>1,103,816,901.97</b>

#### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>345,645,453.00</b>	<b>417,806,085.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>345,645,453.00</b>	<b>417,806,085.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>22,961,453.00</b>	<b>60,445,085.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,961,453.00	60,445,085.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>322,684,000.00</b>	<b>357,361,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	322,684,000.00	357,361,000.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>329,700,453.00</b>	<b>407,826,085.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>329,700,453.00</b>	<b>407,826,085.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>320,677,347.71</b>	<b>376,288,315.01</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>221,586,158.73</b>	<b>218,032,697.43</b>
210101	Үндсэн цалин	138,202,377.36	164,009,499.03
210102	Нэмэгдэл	27,330,612.83	28,943,999.30
210104	Урамшуулал	35,181,465.07	0.00
210105	Гэрээт ажлын хөлс	20,871,703.47	25,079,199.10
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>28,216,389.73</b>	<b>27,937,559.58</b>
210201	Тэтгэврийн даатгал	26,414,348.66	20,094,460.94
210202	Тэтгэмжийн даатгал	394,135.77	1,960,799.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	402,108.63	1,568,599.50
210204	Ажилгүйдлийн даатгал	421,726.97	392,199.51
210205	Эрүүл мэндийн даатгал	584,069.70	3,921,499.80
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>18,000,180.88</b>	<b>25,451,437.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,930,105.88	1,972,419.00
210302	Түлш, халаалт	16,070,075.00	23,379,018.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	100,000.00

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>23,823,090.00</b>	<b>30,677,270.00</b>
210401	Бичиг хэрэг	2,503,250.00	2,266,850.00
210402	Тээвэр, шатахуун	18,617,810.00	25,472,340.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,215,830.00	1,430,680.00
210404	Ном, хэвлэл	200,000.00	50,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	596,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	786,200.00	861,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,334,000.00</b>	<b>2,278,250.00</b>
210502	Хоол, хүнс	434,000.00	84,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	900,000.00	2,194,250.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>0.00</b>	<b>9,669,170.00</b>
210604	Урсгал засвар	0.00	9,669,170.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,405,500.00</b>	<b>1,772,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,405,500.00	1,772,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>15,821,028.37</b>	<b>45,937,171.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,333,468.37	45,253,271.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	620,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	350,000.00	108,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	110,000.00	100,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	96,800.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	340,000.00
210807	Газрын төлбөр	90,760.00	135,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>10,491,000.00</b>	<b>14,532,760.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,200,000.00	14,202,760.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	291,000.00	330,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,023,105.29</b>	<b>31,537,769.99</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,833,000.00</b>	<b>2,099,604.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,833,000.00	2,099,604.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>7,190,105.29</b>	<b>29,438,165.99</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,739,120.66	14,246,351.99
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	450,984.63	15,191,814.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>15,945,000.00</b>	<b>9,980,000.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>15,945,000.00</b>	<b>9,980,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>15,945,000.00</b>	<b>9,980,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>15,945,000.00</b>	<b>9,980,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,945,000.00	9,980,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-15,945,000.00</b>	<b>-9,980,000.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>0</b>	<b>0</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Төсвийн хэмнэлт, хэтрэлт	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>357,361,000.00</b>	<b>343,114,648.01</b>	<b>14,246,351.99</b>	<b>96%</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>357,361,000.00</b>	<b>343,114,648.01</b>	<b>14,246,351.99</b>	<b>96%</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>355,261,000.00</b>	<b>341,015,044.01</b>	<b>14,245,955.99</b>	<b>96%</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>218,032,700.00</b>	<b>218,032,697.43</b>	<b>2.57</b>	<b>100%</b>
Үндсэн цалин	164,009,500.00	164,009,499.03	0.97	100%
Нэмэгдэл	28,944,000.00	28,943,999.30	0.70	100%
Гэрээт ажлын хөлс	25,079,200.00	25,079,199.10	0.90	100%
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>28,632,700.00</b>	<b>27,937,559.58</b>	<b>695,140.42</b>	<b>98%</b>
Тэтгэврийн даатгал	20,789,600.00	20,094,460.94	695,139.06	97%
Тэтгэмжийн даатгал	1,960,800.00	1,960,799.83	0.17	100%
ҮОМШӨ-ний даатгал	1,568,600.00	1,568,599.50	0.50	100%
Ажилгүйдлийн даатгал	392,200.00	392,199.51	0.49	100%
Эрүүл мэндийн даатгал	3,921,500.00	3,921,499.80	0.20	100%
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>30,136,000.00</b>	<b>25,451,437.00</b>	<b>4,684,563.00</b>	<b>84%</b>
Гэрэл, цахилгаан	2,140,000.00	1,972,419.00	167,581.00	92%
Түлш, халаалт	27,896,000.00	23,379,018.00	4,516,982.00	84%
Цэвэр, бохир ус	100,000.00	100,000.00	0.00	100%
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>32,298,000.00</b>	<b>30,927,270.00</b>	<b>1,370,730.00</b>	<b>96%</b>
Бичиг хэрэг	2,520,000.00	2,516,850.00	3,150.00	100%
Тээвэр, шатахуун	26,168,000.00	25,472,340.00	695,660.00	97%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,100,000.00	1,430,680.00	669,320.00	68%
Ном, хэвлэл	50,000.00	50,000.00	0.00	100%
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	596,000.00	-96,000.00	119%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	960,000.00	861,400.00	98,600.00	90%
<b>Нормативт зардал</b>	<b>2,372,000.00</b>	<b>2,278,250.00</b>	<b>93,750.00</b>	<b>96%</b>
Хоол, хүнс	172,000.00	84,000.00	88,000.00	49%
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,200,000.00	2,194,250.00	5,750.00	100%
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>19,400,000.00</b>	<b>19,399,170.00</b>	<b>830.00</b>	<b>100%</b>
Тавилга	9,500,000.00	9,500,000.00	0.00	100%
Урсгал засвар	9,900,000.00	9,899,170.00	830.00	100%
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>8,400,000.00</b>	<b>1,772,000.00</b>	<b>6,628,000.00</b>	<b>21%</b>
Дотоод албан томилолт	8,400,000.00	1,772,000.00	6,628,000.00	21%
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,380,000.00</b>	<b>683,900.00</b>	<b>696,100.00</b>	<b>50%</b>
Даатгалын үйлчилгээ	110,000.00	108,900.00	1,100.00	99%
Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	100,000.00	0.00	100%
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	340,000.00	60,000.00	85%
Газрын төлбөр	150,000.00	135,000.00	15,000.00	90%
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>14,609,600.00</b>	<b>14,532,760.00</b>	<b>76,840.00</b>	<b>99%</b>

Бараа үйлчилгээний бусад зардал	14,279,600.00	14,202,760.00	<b>76,840.00</b>	<b>99%</b>
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	330,000.00	330,000.00	<b>0.00</b>	<b>100%</b>
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,100,000.00</b>	<b>2,099,604.00</b>	<b>396.00</b>	<b>100%</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,100,000.00</b>	<b>2,099,604.00</b>	<b>396.00</b>	<b>100%</b>
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,100,000.00	2,099,604.00	<b>396.00</b>	<b>100%</b>
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>357,361,000.00</b>	<b>343,114,648.01</b>	<b>14,246,351.99</b>	<b>96%</b>
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>357,361,000.00</b>	<b>343,114,648.01</b>	<b>14,246,351.99</b>	<b>96%</b>
Орон нутгийн төсвөөс	357,361,000.00	343,114,648.01	<b>14,246,351.99</b>	<b>96%</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	<b>0.00</b>	<b>0%</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00	<b>0.00</b>	<b>0%</b>

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>60,445,085.0</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	60,445,085.0
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	45,253,271.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	45,253,271.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		45,253,271.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	15,191,814.00
<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	15,191,814.00
Төвлөрүүлэх шилжүүлэг		15,191,814.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>60,445,085.0</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	60,445,085.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	60,445,085.00
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		-
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дэлгэр сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Санчирмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дэлгэр сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 20 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Дэлгэр сумын Засаг даргын тамгын газар нь Засаг даргын хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нь цаг үеэ олсон, оновчтой зөвлөгөө, мэдээллээр ханган бүх талын дэмжлэг үзүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй чанарын өндөр түвшинд хүргэх чиг үүрэгтэй төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дэлгэр сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 493.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 9.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7.8 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд 2021 оны нийт зардал 514.3 сая төгрөгөөс 2 хувиар тооцоход 10.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 8.2 сая төгрөгөөр тооцсон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Дэлгэр сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2 хувиар буюу 23.0 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Авлага дансны үлдэгдэл нь 0.4 сая төгрөг нь нийгмийн даатгалын шимтгэлийн, 0.2 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татвар, 4.3 сая төгрөгийн эзэн холбогдогч нь тодорхойгүй авлаг, 30.1 сая төгрөгийн цалингийн нөхөн олговрын авлагатай байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 82.0 сая төгрөг болж 0.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 52.8 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, хандиваар 3.3 сая төгрөгийн өвс тэжээл хүлээн авч, үйл ажиллагаандаа 56.7 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,630.2 сая төгрөг болж 64.0 сая төгрөгөөр өссөн нь 12.1 сая төгрөгийг төсвийн хөрөнгөөр 76.7 сая төгрөгийн хөрөнгийг Дэлгэр сумын ОНХС, 40.7 сая төгрөгийг хандив тусламжаар үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 65.6 сая төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,103.8 сая төгрөг болж 23.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 45 хувиар буюу 166.8 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого, нэмэлт санхүүжилтийн орлого өссөнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 1,103.7 сая төгрөг болсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 382.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 24.7 сая төгрөгөөр бууруулж, 357.3 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс их байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, нормативд зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг бууруулж баталсантай холбоотой байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 357.3 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 357.3 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 343.1 сая төгрөгийг зарцуулж 14.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 343.1 сая төгрөг буюу 96 хувьтай байгаа Хангамж, бараа материалын зардлыг 1.3 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 4.6 сая төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 6.6 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 0.3 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 0.6 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 60.4 сая төгрөгийн орлого хүлээн авч, 45.2 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил зарцуулж, 15.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, худалдан авалтын и-баримтыг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 886.9 сая төгрөгийн 38 мэдээллээс 387.1 сая төгрөгийн 18 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн, 499.7 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

### **3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт**

Тайлант онд 10.3 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг дутуу шивүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7, Татварын ерөнхий хуулийн 28., 2-т " Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3 дахь заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0.3 сая төгрөгийн төлбөрийн акт, 1.2 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага, 9.9 сая төгрөгийн зөвлөмжийн шийдвэрийн хэрэгжилтийг хангуулсан байна.

### **3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ**

Байгууллагын удирдах албан тушаалтныг Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэг, 43 дугаар зүйлийн 43.3 дахь заалтыг зөрчиж томилсон байна

Дараа жилийн аудитаар

- Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудлыг авч үзэх
- Бараа материалын тайлангийн тулгалт,
- Худалдан авалтын и баримтын шивэлтийг бүрэн хийсэн эсэх
- Төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлсэн эсэхийг зүйтэй гэж үзлээ

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 134.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 69.1 сая төгрөгийн алдааг залруулж, 0.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 64.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

### **4.1 Залруулсан алдаа**

Санхүүгийн тайланд 2.0 сая төгрөг, үр дүнгийн тайланд 2.4 сая төгрөгийн зөрүүтэй байсныг аудитын явцад байгууллагын удирдлага, нягтлан бодогч хүлээн зөвшөөрч санхүүгийн тайланд залруулав. Зардлыг түүвэрлэн үзэхэд 64.6 сая төгрөгийн и-баримтгүй худалдан авалт хийсэн байсныг аудитын явцад нөхөж шивүүлсэн.

### **4.2 Төлбөрийн акт**

Цалингийн урьдчилгаа суутгаагүй 0.1 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дахь заалт "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар

төлөвлөж зарцуулах"-ыг, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт "Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

#### 4.3 Албан шаардлага

Олон жилийн насжилттай 4.3 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20 дугаар зүйлийн 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Тайлант онд Цалингийн нөхөн олговор 1.0 сая төгрөгийн олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20 дугаар зүйлийн 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Батлагдсан орон тооноос 1 орон тоогоор илүү ажиллуулж 0.6 сая төгрөгийн зарцуулсан байна. нь Засгийн газрын 2009 оны 13 дугаар тогтоол "Сумын Засаг даргын тамгын газрын орон тооны хязгаарыг тогтоох тухай" нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлалгүйгээр 5.6 сая төгрөгөөр тавилга бэлтгэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалт "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон Баян-Уул сумын Засаг даргын тамгын хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Тайлант онд 10.3 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг дутуу шивүүлсэн нь Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий,

нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоор 36.9 сая төгрөгийн илүү, 0.1 сая төгрөгийн дутуу төлөлт татварын цахим системд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тайланд цалингийн зардлыг 5.7 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-т "Татвар төлөгч татварын тайланг хуулиар тогтоосон хугацаанд, батлагдсан загвар, зааврын дагуу цахим, эсхүл цаасан хэлбэрээр үйлдэж, харьяа татварын албанд тушаана. Татвар төлөгч дараах үүргийг хүлээнэ: 29.1.3.суутгасан татварыг хуульд заасан хугацаанд харьяа татварын албанд үнэн зөв тайлагнах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

#### 4.4 Зөвлөмж

Аудитаар илэрсэн 1 алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

##### 1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 886.9 сая төгрөгийн 38 мэдээллээс 387.1 сая төгрөгийн 18 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн, 499.7 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна.

- 1.1. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл," гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах
- 1.2. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дэлгэр сумын Засаг даргын тамгын газар	12	134.0	2	69.1	1	0.1	8	64.8	1	0

/сая төгрөгөөр/